

## ҮНС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2023 оны 09 сарын 20 -ний өдөр  
2023.10.17

Дугаар 46/2023/08 Улаанбаатар хот  
2023/10

Энэхүү гэрээг Монгол улсын Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243-261 дүгээр зүйл, бусад хууль тогтоомжийн хүрээнд нэг талаас “Амгалан дулаан станц” ТӨХК /Цаашид худалдагч гэх/ нөгөө талаас “Монцемент билдинг материалс” ХХК/ Цаашид худалдан авагч гэх/ дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцож гэрээ байгуулав.

### НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. “Амгалан дулааны станц” ТӨХК болон “Монцемент билдинг материалс” ХХК нарын хооронд байгуулсан Үнс худалдах, худалдан авах тухай, төлбөр тооцоо, талуудын эхр, үүрэг, хариуцлага харилцааг хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 2.1. Талууд энэхүү гэрээний үндэслэл болгосон баримт бичгийн үзэл санааг хэрэгжүүлж олон улсын худалдааны зарчимд нийцсэн, холбогдох хууль тогтоомжийг баримтлан хамтын ажиллагаагаа боловсронгуй болгон харилцан ашигтай ажиллаж, Үнс худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлнэ.
- 2.2. Энэхүү гэрээгээр нийлүүлэх үнсний чанар нь стандартын шаардлагыг хангасан байна.
- 2.3. Талууд гэрээгээр тохиролцсон үнэ, хэмжээ, нөхцөлөөр үнс нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.4. Худалдагч, худалдан авагчид энэхүү гэрээний дагуу 2023 оны 09 дүгээр сарын 20-ний өдрөөс 2024 оны 05 сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд өдөрт 30-210 тонн үнс нийлүүлнэ.
- 2.5. Талууд гэрээг бүрэн биелүүлсэн нөхцөлд энэхүү гэрээг цаашид үргэлжлүүлэн сунгах, нийлүүлэх үнсний хэмжээ, үнийг дахин тохиролцож болно.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

- 3.1. Энэхүү гэрээгээр нийлүүлэгдэх үнсний үнэ 1/нэг/ тонн тутамд НӨАТ тооцсон үнээр 15,000 (Арван таван мянган) төгрөгөөр тооцно.
- 3.2. Энэхүү үнэнд пүүний бичгийг үндэслэн дараа тооцоот нөхцөлөөр төлөх худалдан авагчийн үнс хүлээн авах талбайд хүргэх төлбөр болон авто зам ашигласны, тээвэр зохион байгуулалт, замын хураамж, шатахууны зардал гэх мэт бусад зардлууд багтсан болно.



## **ДӨРӨВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

- 4.1. Худалдан авагч нь өөрийн Монцемент үйлдвэрийн пүүгээр үнсийг жинлэн хүлээн авч, үнсний тооцоог сар бүрийн 25-ны өдрүүдэд тооцоо нийлж, тооцоо нийлсэн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 4.2. Энэхүү гэрээний 4.1-д зааснаар төлбөр тооцоог нийлсэн тухайн сар бүр заасан хугацаанд хийгээгүй нөхцөлд үнс нийлүүлэлтийг зогсооно.
- 4.3. Худалдан авагч тал гэрээгээр авах үнсний үнийг дараа тооцох нөхцөлөөр төлбөрийг “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Хаан банкны 5131101050 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

## **ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1. Худалдан авагч тал Худалдагч талтай хамтран аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангаж ажиллана. Тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн буруутай үйлдлээс болж гарсан нэмэгдэл зардал, алдагдлыг Худалдан авагч тал хариуцахгүй болно.
- 5.2. Худалдагч тал сар бүрийн 25-ны өдөр тооцоо нийлж төлбөр тооцоог бүрэн шилжүүлж байна.
- 5.3. Худалдагч тал нь өөрийн эзэмшлийн тусгай зориулалтаар тоноглогдсон машинаар үнсний тээврийг хийх ба тээврийн хэрэгсэлтэй холбоотой бусад зардал, хураамжийг хариуцна.

## **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА БА МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 6.1. Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд талууд гэрээгээр гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоногийн 0,5 хувийн алданги тооцно.
- 6.2. Худалдагч, Худалдан авагч тал аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 6.3. Энэхүү гэрээний 4.1-д заасны дагуу төлбөр хийгдээгүй нөхцөлд үнс нийлүүлэлтийг зогсоох бөгөөд үүнээс гарах хохирлыг Худалдагч хариуцахгүй.
- 6.4. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй, өөр бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд нөгөө талдаа энэ тухайгаа бичгээр яаралтай мэдэгдэж тодорхой арга хэмжээ авна

## **ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 7.1. Энэхүү гэрээний дагуу үнс нийлүүлэх явцад газар хөдлөлт, гал, усны аюул зэрэг олон улсын давагдашгүй нөхцөл бий болж тасалдахад хүрвэл талууд энэхүү гэрээний үйлчлэх хугацааг түр зогсоож дахин сунгах талаар харилцан тохиролцоно.
- 7.2. Давагдашгүй нөхцөл үүссэн хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргийг үл биелүүлсний хариуцлага хүлээхгүй бөгөөд гэрээг зогсоож, түдгээлзүүлэх, аль эсвэл сунгах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.



## НАЙМ. БУСАД НӨХЦӨЛ

- 8.1. Гэрээнд талууд гарын үсэг зурж тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээнд заасан эрх, үүрэг, бусад нөхцлүүдийг хоёр тал харилцан биелүүлнэ.
- 8.3. Гэрээнд оруулах аливаа өөрчлөлтийг бичгээр үйлдэж хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулна. Гэрээг Монгол хэл дээр тус бүр 1 /нэг/ хувь үйлдэнэ.

## ЕС. ТАЛУУДЫН АЛБАН ЕСНЫ ХАЯГ:

9.1.1 Нийлүүлэгч талын хаяг: Амгалан дулааны станц ТӨХК нь БЗД-ийн 8 дугаар хороо, УС-15-1-1, Ботаникийн эцэс. Утас: 77111257, 99047300, 99662289


9.1.2 Худалдан авагч талын хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Автозамчдын гудамж-30, Монполимет цогцолбор, Утас: 99780740, 88111977

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


ХУДАЛДАГЧ ТАЛ:

ХУДАЛДАН АВАГЧ ТАЛ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
 М.МӨНХӨӨ


ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  
 Э.МӨНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 О.УДВАЛ

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ  
ГЭРЭЭ,БОРЛУУЛАЛТЫН  
ИНЖЕНЕР

 Б.БАТЦООЖ

ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЭЛСӨН ЗАХИРАЛ

  
Ц.ХАЛИУН  
ХУДАЛДАН АВАЛТЫН  
МЕНЕЖЕР

 К.ЛАМАН

]